

ТАХАРЫН АЛБАНЫ ТУХАЙ ХҮҮЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Долгосүрэнгийн Булган

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, цагдаагийн эрх
зүйн тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахмад

Монгол Улсад шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах, түүнчлэн шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, шүүх хуралдаанд албадан ирүүлэх, оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах зэрэг ажиллагааг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөр өөрийн эрх хэмжээний хүрээнд тус тусын хууль, журмын дагуу хэрэгжүүлж байв.

“Тахарын албаны тухай хууль” батлагдан гарсанаар шинэ эрх зүйн зохицуулалт, бие даасан байгууллага, алба бий болсон.

Монгол Улсад тахарын албаны үйл ажиллагааг зохицуулхаар “Маршалын албаны тухай хууль” нэртэй төсөл Монгол Улсын Улсын Их хуралд өргөн баригдсан бөгөөд “Тахарын албаны хууль” болон өөрчлөгдөн батлагдсан.

Гадаадын зарим улс оронд тэр дундаа АНУ болон европын зарим ороны туршлагаас дээрх чиг үүргийг мэргэшсэн буюу “MARSHAL” гэх тусгай албаар гүйцэтгүүлдэг байна. Ингэснээр шүүгчийн хараат бус байх нөхцөл бодит утгаараа хэрэгжиж улмаар хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хангах үндэс болдог байна.

MARSHAL гэдэг нь үг нь сүүлийн хэдэн зууны турш цэрэг, иргэний хууль сахиулах байгууллагын өндөр дээд албанд “маршал” цол болгон хэрэглэсээр ирсэн бөгөөд ерөнхий нэршил юм¹ “Маршал” гэдэг үг нь эртний Франц хэлний “marhsalk” буюу “сахиулагч, үйлчлэгч” гэх үгнээс гаралтай Франц хэлний зээлбэр үг юм. Эртний гярман хэлний “marascailh” (marah-адуу, scalc-зарц) “агтчин”, Орчин үеийн гярман хэлэнд “цэргийн каммандлагч” гэсэн үгнээс гаралтай аж.

Маршал гэдэг нь олон салбарт албан ёсны цолны нэршлээр хэрэглэгддэг. Тухайлбал маршал гэдэг нь АНУ-д цэрэгжүүлсэн цагдаа, агаарын халдлага дайралтаас хамгаалах үүрэг бүхий “Холбооны агаарын маршалын үйлчилгээний байгууллага” буюу тусгай газар, иргэний байгууллагын хувьд коллеж, их сургуульд² уралдааны тэмцээний үед³, “маршал” гэх хүмүүс ажилна.

АНУ-ын мужуудад хууль сахиулах байгууллагын хувьд маршал нь төрийн, орон нутгийн, хотын; захиргааны шүүхийн байгууллагад шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, цагдаагийн үүрэгтнээр ажиллаж, дүрэмт хувцас өмсдөг бөгөөд хууль сахиулах буюу иргэний эрхийн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Ерөнхийдөө шүүхийн аюулгүй байдалд анхаарал хандуулан ажилладаг байгуулга юм.

АНУ-ын Маршалын албаны бүтэц⁴

¹ Webster's Encyclopedic Unabridged Dictionary of the English Language. New York: Gramercy Books. 1996. p. 879. ISBN 0-517-15141-3.

² АНУ-д коллеж, их сургуульд маршал цолыг хэрэглэж болдог бөгөөд ерөнхийдөө бусдыг манлайлан удирдаж өглөөний дасгал хийх, хурал цуглаан зохион байгуулах, төгсөлт, ойн баяр тэмдэглэх зэрэг баярын арга хэмжээг даргалан зохион байгуулж байгаа ахлах буюу төгсөх ангийн оюутанд олгодог.

³ Мото спортын уралдаан зохион байгуулагч, туг барин зогсон хүмүүсийг маршал гэх нь бий. Мөн гольфын спортод тоглогч нарыг шүүх хамгын ахлах шүүгчид маршил цол олгодог.

⁴ http://www.usmarshals.gov/foia/strategic_plan-2016.pdf “United States Marshals Service. Strategic plan 2012-2016” 8 дахь тал



Тухайлбал АНУ-ын олон хотуудад маршалын тогтолцоотой ба гол үүрэг нь орон нутгийн болон төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах арга хэмжээ авна. Индиана мужад IC36-5-7 кодоор маршалыг “хотын цагдаагийн офицер, хууль сахиулах байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх эрх бүхий ажилтан” гэж тодорхойлсон. Маршал нь дараахь үүрэгтэй.

- Хотын шүүх, хуулийн байгууллагаас өөрт оноосон үүргээр иргэнийг шүүхэд дуудах,
- Хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, шүүхийн байгууллагад хүргэх, хэргийг бүрэн шийдвэрлэж дуустал гэмт этгээдийг харгалзах,
- Хэв журам сахиулан аливаа зөрчлийг хянах,
- Шаардлагатай үед төв албанаас нэмэлт хүч дуудах,
- Эрэн сурвалжлах, баривчлах,
- Гэмт этгээдийг даган мөрдөх, хориулах зэрэг үйл ажиллагаа хийгддэг⁵.

Харин Монгол Улсад “Тахарын албаны тухай хууль” 2013 оны 7-р сарын 5-ны өдөр УИХ-аас батлагдаж, Засгийн газрын 2014 оны 01-р сарын 11 өдрийн “Агентлаг байгуулах тухай” 07-р тогтоолоор тахарын алба байгуулагдан, Хууль зүйн сайдын 2014 оны 1-р сарын 27-ны өдрийн А\08 дугаар тушаалаар тахарын албаны зохион байгуулалтын бүтэц батлагдан үйл ажиллагаа явуулж байна.

“Тахарын албаны тухай хууль”-иар шүүх, шүүгч, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны дэг сахиулах, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалахаас гадна шүүн таслах үйл ажиллагааны гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг

⁵ <http://en.wikipedia.org/wiki/Marshal>

хамгаалах, ялтан, яллагдагчийн хуяглан хүргэх, мөрдөн шалгах, эрэн сурвалжлах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тахарын алба⁶ гэдэг нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгуулага юм.

Шүүхийн аюулгүй байдал гэдэгт нэн тэргүүнд шүүх хуралдааны дэг журмыг сахиулах ажиллагаа хамаарах бөгөөд шүүхийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн баталсантай холбогдуулан тахарын албыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх шаардлагатай байна.

Шүүх хуралдааны дэг журам гэдэгт зөвхөн шүүх хуралдааны танхимд хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаагаар зогсохгүй, шүүхийн мэдээлэл, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хамгаалалт зэрэг нэлээд өргөн цар хүрээтэй ажиллагааг ойлгоно.

Мөн оргон зайлсан шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэхээс гадна хорих ангид нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрийн хүчээр зогсоох боломжгүй бол тахарын албанд хүсэлт гаргаснаар тодорхой чиг үүргийг гүйцэтгэх болно.

Харин өмнөх практикт шүүгдэгч, ялтан оргон зайлсан тохиолдолд цагдаа, дотоодын цэргийг дайчлан ажиллуулж байсан бөгөөд энэ байгууллага байгуулагдснаар шүүгдэгч, ялтныг оргон зайлж болзошгүй нөхцөл байдалд зохицсон арга хэмжээг цаг алдалгүй мэргэжлийн байгууллага ажиллахаар болжээ.

Түүнчлэн гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг “Тахарын албаны хууль”-иар зохицуулсан бөгөөд гэмт хэргийг шалган тогтоох, нотлох ажиллагаа нь үндсэндээ гэрч, хохирогчийн мэдүүлэгт үндэслэгддэг бөгөөд тэдний аюулгүй байдлыг хамгаалах асуудал чухлаар тавигдав.

Тахарын албаны тогтолцоо. Тахарын алба нь тахарын албаны төв байгууллага болон тойргийн журмаар зохион байгуулагдсан тахарын албад буюу "тойргийн тахарын алба" -аас бүрдэхээр хуулинд заасан. Тойргийн тахарын албаны бүтцийг Хууль зүйн сайдын 2014 оны 3-р сарын 11-ний А\29 дүгээр тушаалаар батлан тойргийн шүүхийн бүсчлэлийн дагуу 1-10 тойргийн журмаар 22 хэсэг байхаар улсын хэмжээнд зохион байгуулсан.

Тахарын албаны төв байгууллага нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, захиргааны удирдлага, санхүү, хангалт үйлчилгээ хариуцах, **дотоод хяналт-аюулгүй** байдлыг хангах чиг үүрэг бүхий үндсэн бүтэцтэй байна.

Дотоод хяналт-аюулгүй байдлын нэгжийг бусад чиг үүрэг хариуцсан нэгжээс бие даалган байгуулах бөгөөд дотоод хяналт-аюулгүй байдлын алба хаагчийг тус нэгжийн даргад мэдэгдэхгүйгээр томилох, өөрчлөх, чөлөөлөхийг хориглоно.

Тахарын албаны шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үндсэн бүтэц нь дараахь чиг үүрэг бүхий нэгжтэй байна:

- 1.Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;
- 2.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах;
- 3.Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах;
- 4.яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 5.Бусад нэгж байж болно.

Тахарын алба дэргэдээ сургалтын түшиц газар, өөрийн үйл ажиллагааны чиглэлээр шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий нэгжтэй байж болно.

Тахарын алба шаардлагатай тохиолдолд шүүн таслах ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, шүүхэд ирсэн нотлох баримтыг хадгалах, хамгаалах, хуулиар шүүх хуралдаанд

⁶ Тахарын албаны тухай хууль. –УБ, 2013 он 1 дүгээр зүйл

зайлшгүй оролцуулахаар заасан зохигч, хэргийн оролцогчийг албадан авчрах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тахарын албаны бүрэн эрх, гүйцэтгэх үйл ажиллагаа. Гадаадын зарим улс орнуудад маршалын алба нэртэйгээр энэхүү үйл ажиллагааг явуулдгыг өмнө дурдсан бөгөөд “тахарын албаны тухай хууль” батлагдан гарсан нь Монгол Улсад шинэлэг зүйл юм.

Тахарын алба нь хуульд заасан үүргээ гүйцэтгэхдээ шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахдаа урьдчилан сануулах, биечилсэн болон техникийн хамгаалалт зохион байгуулах, бусад хамгаалалтын арга хэмжээг авч ажиллана.

Шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулж шүүгч, түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэнд, шүүгчийн эд хөрөнгөд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй бодит нөхцөл байдал үүсвэл шүүгч өөрийгөө болон өөрийн хамаарал бүхий этгээд, эд хөрөнгөө хамгаалалтад авахуулах тухай хүсэлтээ тойргийн тахарын албанд гаргана.

Тойргийн тахарын алба хүсэлтийг хүлээн авч, нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай гэж үзвэл энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг нэн даруй зохион байгуулна.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хугацааг тойргийн тахар тогтоох бөгөөд уг хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл тэргүүн тахард танилцуулж шийдвэрлэнэ.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах дараахь арга хэмжээнүүдийг авна.

Урьдчилан сануулах. Шүүх, шүүгчийн аюулгүй байдалд заналхийлж, хор аюул учруулж болзошгүй нь тогтоогдсон этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар Тахарын албаны алба хаагч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

Биечилсэн болон техникийн хамгаалалт. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Тахарын албанаас тодорхой хугацаагаар биечлэн, эсхүл тусгай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан хяналт тавьж хамгаална.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдалд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй бодит нөхцөл байдал тогтоогдвол биечилсэн болон техникийн хамгаалалтын арга хэмжээг нэн даруй авна.

Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай гэж үзвэл шүүгчийн биед болон гэрт тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

Бусад хамгаалалтын арга хэмжээ. Шаардлагатай тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэнэ.

Шүүх хуралдааны журам сахиулах, аюулгүй байдлыг хангах. Тахарын алба шүүхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүх хуралдааны танхимд эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Тахарын албанаас шүүхийн хуягийг томилно.

Тахарын албанаас шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах явцад аюултай, гэнэтийн нөхцөл байдал үүсвэл шүүх хуралдааныг түр хугацаагаар завсарлуулахаар шүүх хуралдаан даргалагчид үндэслэл бүхий санал тавьж шийдвэрлүүлнэ.

Тахарын алба нь шүүх хуралдааны явцад үүсч болох эрсдэлтэй нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид үндэслэл бүхий санал хүргүүлж болно.

Тахарын албыг тэргүүн тахар удирдах бөгөөд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Тахарын албаны үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдах;

2. Тахарын албаны үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн батлах, мөрдүүлэх;

3.Тахарын албаны чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлэл өгөх, санал тавих;

4.Тахарын албаны үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг шийдвэрлэх;

5.Тахарын албыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах, хамтран ажиллах гэх мэт.

Тахарын алба нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1.шүүхийн харуул хамгаалалтыг хэрэгжүүлэх, шүүх хуралдааны журам сахиулах;

2.шүүхийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, өөрчлөх, засварлахад аюулгүй байдлын зөвлөмж гаргах;

3.шүүгчид аюулгүй байдлын хамгаалалтын талаар сургалт явуулах;

4.шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах;

5.яллагдагчийг хуяглан хүргэх;

6.шүүхийн дуудснаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх;

7.оргон зайлсан яллагдагчийг эрэн сурвалжлах, баривчлах зэрэг болно.

Тархарын алба нь **яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх, гэрч, хохирогчийг хамгаалах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, эрэн сурвалжлах** зэрэг ажиллагааг явуулна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд Тахарын алба нь Монгол Улсын хувьд цоо шинэ зүйл бөгөөд суурь эрх зүйн зохицуулалт бий болсон хэдий ч ирээдүйн чиг хандлагыг зөв тодорхойлж, үйл ажиллагаагааны талаархи дүрэм журмыг боловсруулж, цаашдын бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг даван туулах арга замыг тодорхойлох нь зайлшгүй юм.

Тахарын албаны үйл ажиллагааг сайжруулахад дараахь арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй мэт санагдана.

- Гэрч хохирогчийг хамгаалах хөтөлбөр боловсруулах
- Тахарын албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам стандартыг батлуулж мөрдүүлэх
- Тахарын албаны цаашдын чиг хандлагыг тодорхойлох “Стратегийн төлөвлөгөө” боловсруулах

Энэхүү төлөвлөгөөнд тахарын албаны өмнө тулгарах бэрхшээл, түүнийг даван туулах стратегийг тодорхойлж болох юм. Үүнд үйл ажиллагааны замын газрын зураг, тахарын албаны нөөцийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг хамаарна.

Энэ стратегийн төлөвлөгөө нь тахарын албаны ажиллах хүч, эрхэм зорилгыг тусгасан байна. Тухайлбал:

- Хамгийн үр дүнтэй, үр ашигтай арга замаар шүүхийн үйл явцыг хамгаалах.
- Дотоодын болон олон улсын судалгааны үр дүнг судалж, туршлага нэвтрүүлэх
- Зардлын үр ашигтай байдлаар шүүхийн аюулгүй байдлыг хангах, гэрч хохирогчийг хамгаалах, хүмүүнлэглэгээр тээвэрлэн хүргэхэд илүү хөгжилтэй зарим орны ажлын туршлагыг үндэсний тахарын албаны үйл ажиллагааг оновчтой болгоход анхаарах
- Тахарын албаны ажилтны аюулгүй байдлыг хангах талаар санаачлага гаргаж үр дүнтэй ажлыг зохион байгуулах
- Тахарын ажилтны мэргэжлийн, хариуцлагыг дээшлүүлэх, шинэчлэлийг сурталчлах
- Тахарын албаны үйл явц, тогтолцоог боловсронгуй болгож, хүчтэй, үр дүнтэй үйл ажиллагааны дэд бүтцийг бий болгох.